

ТАНИЛЦУУЛГА

Улсын Их хурлын дарга болон эрхэм гишүүд та бүхний энэ өдрийн мэндийг хүргэе.

Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогыг Статистикийн тухай хууль, Хүн ам орон сууцны улсын тооллогын тухай хууль болон НҮБ-аас гаргасан зөвлөмжийн дагуу амжилттай зохион байгууллаа.

Энэ удаагийн тооллогын товыг УИХ-ын 2017 оны 76 дугаар тогтоолоор “2020 оны 1 дүгээр сарын 8-наас 9-нд шилжих шөнийн Улаанбаатарын 00 /тэг тэг/ цагаар” тогтоож, тоолох ажиллагааг хуульд заасны дагуу 7 хоногийн хугацаанд зохион байгуулсан болно.

УИХ-ын 2017 оны “Улсын комисс байгуулах тухай” 77 дугаар тогтоолын дагуу Улсын тооллогын Комиссыг Монгол Улсын Ерөнхий сайд ахалж, Засгийн газрын гишүүд, бүх шатны засаг дарга нар хуулиар хүлээсэн үүргийн дагуу тооллогын ажилд онцгой ач холбогдол өгч ажиллалаа.

Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын дүнгээр Монгол Улсын хүн ам 3 296 866, ерхийн тоо 897 427 болов. Өөрөөр хэлбэл Монгол Улсын хүн ам өмнөх тооллогоос буюу 2010 оноос хойш жилд дунджаар 2.2 хувиар өсжээ.

Тооллогоор гарсан гол үр дүнгээс танилцуулбал:

- Монгол Улсын хүн ам нь насны бүтцийн хувьд залуу хэвээр байна. Тухайлбал нийт хүн амын:
 - 31.5 хувийг 0-14 насны хүүхэд,
 - 64.4 хувийг 15-64 насны хүн ам,
 - 4.1 хувийг 65 ба түүнээс дээш насны хүн ам эзэлж байна.

Хүн амын ачаалал буюу хөдөлмөрийн насны 100 хүнд ногдох хүүхэд, ахмад настан гэх мэт тэжээлгэгч хүн амын тоо 55.3 байна. Хүн амын голч нас 27.9 болсон нь сүүлийн 30 жилд голч нас 10 насаар нэмэгдсэнийг илэрхийлж байна.

- Монгол улсын нийт хүн амын 3.7 хувь буюу 122 мянган хүн гадаадад 6 ба түүнээс дээш сарын хугацаагаар оршин сууж байна. Иргэдийн гадаад улс руу явсан зорилгыг оршин суугаа улсаар авч үзвэл Энэтхэг, ОХУ, БНХАУ, Япон, Австрали, Герман, Ирланд улсад суралцахаар, Казахстан, Польш, Их Британи, АНУ-д суурьшихаар, БНСУ, БНЧУ, Унгар, Швед, Турк, Швейцар, Польш улсад хөдөлмөр эрхлэхээр түлхүү явсан байна.
- Нийт хүн амын 46 хувь нь Улаанбаатар хотод, 19 хувь нь Хангайн бүсэд, 16 хувь нь Төвийн бүсэд, 13 хувь нь Баруун бүсэд, 7 хувь нь Зүүн бүсэд оршин сууж байна.

Хүн амын аймаг, нийслэл хоорондын шилжих хөдөлгөөнд оролцогчид нийт суурин хүн амын 23 хувийг эзэлж байгаа нь өмнөх тооллогын дүнгээс буурчээ. Шилжих хөдөлгөөнд оролцогчдын талаас илүү (68 хувь) нь Улаанбаатар хот руу шилжиж ирсэн байна. Дараа нь Орхон, Дархан-Уул, Сэлэнгэ, Төв аймагт шилжин ирэгчид хамгийн өндөр байна.

- Улсын хэмжээнд 106.4 мянган хөгжлийн бэрхшээлтэй иргэд байгаа нь нийт суурин хүн амын 3.3 хувийг эзэлж байна.
- Арван тав, түүнээс дээш насны хүн амын 98.7 хувь нь бичиг үсэг тайлагдсан байна. Арав, түүнээс дээш насны хүн амын 95.1 хувь нь ямар нэгэн түвшний боловсролтой байна.
- Улсын хэмжээнд өрхийн ам бүлийн дундаж тоо 3.6 байна.
- Анхны гэрлэлтийн дундаж нас 27.7 болжээ.
- Монгол Улсын Зургаа ба түүнээс дээш насны нийт суурин хүн амын 87.8 хувь нь гар утас хэрэглэж байгаа бол 64.7 хувь нь интернэт хэрэглэгчид байна.
- Улсын хэмжээнд арван тав, түүнээс дээш насны нийт хүн амын 59.7 хувь нь ажиллах хүчинд, 40.3 хувь нь ажиллах хүчнээс гадуурх хүн амд багтаж байна. Ажилгүйдлийн түвшин 2020 онд 9.9 хувь болж, өмнөх тооллогын үеийнхээс 5.4 пунктээр буурчээ.
- Байшин, орон сууцны тооллогоор хүн байнга амьдарч байгаа 770.9 мянган сууцанд 897.4 мянган өрх амьдарч байна.
- Тооллогоор нийт өрхийн 38.2 хувь нь монголын уламжлалт сууц болох гэрт, 60.9 хувь нь байшинд, 0.9 хувь нь бусад төрлийн сууцанд амьдарч байна. Инженерийн бүрэн хангамжтай орон сууцанд нийт өрхийн зөвхөн 30 хувь нь амьдарч байна.

Үндэсний статистикийн хорооноос Хүн ам, орон сууц 2020 оны ээлжит тооллогын дунд үндэслэн хүн амын хэтийн тооцоог аймаг, нийслэлээр 2021 тооцож гаргах бөгөөд энэ нь боловсрол, эрүүл мэнд, дэд бүтэц, харилцаа холбоо гэх мэт бүхийн салбарын бодлого төлөвлөлтөд ашиглагдах болно гэдэгт итгэлтэй байна.

УИХ-ын дарга, эрхэм гишүүд та бүхэнд Хүн ам орон сууцны тооллогын тухай хуулийн дагуу Улсын Их хурлаас томилогдсон тооллогын улсын комиссоос тооллогын үр дүнг танилцуулж буйг хүлээн авна уу.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО